



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/03

Чингис хот

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу гэр бүлийн хэрэгцээ, үр тарианы зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэн Ж.Даваасүрэн, Д.Лхагвасүрэн нарын холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг 1 дүгээр хавсралтад дурдсанаар 2 иргэний 2 нэгж талбарыг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн 3.Урангоод үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2011 оны А/63 дугаар захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР



Хэрлэн сумын Засаг даргын 2024 оны
01 дугаар сарын 02-ны өдрийн 1/03
дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

Д/д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Жанчивдорж Даваасүрэн	Гэр бүлийн хэрэгцээ	1200м2	4-р баг, Хэрлэн 12-08 тоот	Болдбаатар Ганбат /СЮ95112817/	44	Эрх шилжүүлэх гэрээ
2	Дэмбэрэл Лхагвасүрэн /СЮ54070769/	Хаваржаа	10000м2	7-р баг, Өвдгийн булаг	Ганбаа Жавзандагтор /СЮ54070769/	13	Эрх шилжүүлэх гэрээ